



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 11/04.

Хөхбүрд

Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 11 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажил, арга хэмжээний сонгон шалгаруулалт, явц үр дүн, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Жамбалдорж (Хурлын төлөөлөгч)

Гишүүд: Д.Батбаатар (Хурлын нарийн бичгийн дарга)

Б.Пүрэвсүрэн (Хурлын төлөөлөгч)

Б.Эрдэнэбаатар (Хурлын төлөөлөгч)

Д.Гансүх (Хурлын төлөөлөгч)

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл, хөтөлбөрийн ажлын явцад, хяналт шалгалт тогтмол хийж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Жамбалдорж)-д үүрэг болгосугай.

3.Төсвийн хүрээний жилд зохион байгуулсан төсөл, арга хэмжээнд, хяналт шалгалт хийсэн гүйцэтгэлийн тайланг ээлжит Хуралдаанд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэгт даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороонд хариуцуулсугай.

ДАРГА



Б.ОТГОНБАЯР

648801067